

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2020.03.03

Улаанбаатар хот

1. **Нийслэлийн Авто замын хөгжлийн газар** дараах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү **Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх** “Нийслэлийн төр захиргааны байгуулллагуудыг Хан-уул дүүргийн нутаг, дэвсгэр, Яармаг дэд төвд шилжүүлэн байршуулах болсонтой холбогдуулан шинээр барих авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах” **зөвлөх үйлчилгээ**.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараахь мэдээллийг ирүүлнэ.

1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх
2. Тусгай зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх
3. Ижил төстэй ажил хийж гүйцэтгэж байсан туршлагын талаарх мэдээлэл /2017, 2018, 2019 он /
4. Зөвлөх хуулийн этгээдийн ажиллах боловсон хүчний чадавхийн талаарх мэдээлэл / ИТА-ын ур чадварын мэдээлэл , туршлага холбогдох баримт бичгүүд /
5. Зөвлөх хуулийн этгээдийн санхүүгийн чадавхийн мэдээлэл /Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 он/ санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан дүгнэлт/
6. Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын аль нэг жилд ижил төстэй зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байх
7. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, ураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн тухай баримт / сүүлийн 7,8,9 сарууд / Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт /Хэвлэмэл хуудсыг үнийн саналын баримт бичигт ирүүлэх ба ингэхдээ хуудсын доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлнэ. Тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. МУ-ын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй бол тендер оролцогчийг ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ/

Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 9:00 цагаас 2020 оны 3 дугаар сарын 11-ны өдрийн 18:00 цаг хүртэл** авч болох бөгөөд Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр мэдүүлгээ **2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 09:30 цагийн дотор ирүүлнэ үү.**

Монгол, Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Нийслэлийн нутгийн захиргааны
2-р байр Хангарди ордон, Утас: 88100762 , Факс: 11-323662
Имэйл хаяг: tugsoo8810@gmail.com